ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ОРА-2022/61/НА-СТА-ТШ3


Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Буян-Ундрах

Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
3. Аудитын тайлан ....10
3.1 Ерөнхий зүйл ....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....11
3.4 Материаллаг байдал ....11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....12
3.8 Аудитын гол асуудал ....13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....13
4. Аудитын илрүүлэлт ....13
4.1 Залруулсан алдаа ....14
4.2 Төлбөрийн акт ....14
4.3 Зөвлөмж ....12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 87

танай ____________ -ны № ____________ -т

ОРХОН АЙМГИЙН 17 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.АЛТАНЗАЯА ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 17 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

17 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 98,344,389.57 | 97,921,803.78 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,209,242.73 | 1,549,242.73 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 2,209,242.73 | 1,549,242.73 |
| 3121 | Төгрөг | 2,209,242.73 | 1,549,242.73 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 2,209,242.73 | 1,549,242.73 |
| 33 | АВЛАГА | - | 8,859,600.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 8,859,600.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 96,135,146.84 | 87,512,961.05 |
| 351 | Түүхий эд материал | 41,977,371.00 | 35,966,643.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 41,977,371.00 | 35,385,993.00 |
| 35130 | Эм боох материал | - | 580,650.00 |
| 354 | Хангамжийн материал | 54,157,775.84 | 51,546,318.05 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,130,150.00 | 1,430,895.45 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,255,000.00 | 4,732,800.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,588,500.00 | 3,796,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 44,184,125.84 | 41,586,122.60 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,376,840,306.15 | 4,276,828,387.18 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,376,840,306.15 | 4,276,828,387.18 |
| 392 | Биет хөрөнгө | 3,923,265,306.09 | 3,823,398,387.08 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,943,214,004.20 | 3,943,214,004.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (153,935,404.96) | (232,132,937.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 200,515,931.63 | 203,381,431.63 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (131,299,474.98) | (146,796,472.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 120,921,544.90 | 120,921,544.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (56,151,294.70) | (65,189,183.23) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 4,309,219.00 | 4,309,219.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (4,309,219.00) | (4,309,219.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 453,575,000.06 | 453,430,000.10 |
| 39301 | Програм хангамж | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (784,999.94) | (929,999.90) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 452,910,000.00 | 452,910,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,475,184,695.72 | 4,374,750,190.96 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,475,184,695.72 | 4,374,750,190.96 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,475,184,695.72 | 4,374,750,190.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,872,083,874.65 | 1,872,083,874.65 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,872,083,874.65 | 1,872,083,874.65 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,910,701,836.66 | 1,810,267,331.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,910,701,836.66 | 1,910,701,836.66 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (100,434,504.76) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 692,398,984.41 | 692,398,984.41 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,475,184,695.72 | 4,374,750,190.96 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,298,603,028.52 | 1,298,104,012.41 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 65,942,345.52 | 18,326,566.96 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 65,942,345.52 | 18,326,566.96 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 65,942,345.52 | 18,326,566.96 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,401,022.00 | 11,428,900.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө | | 2,865,500.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал | | 4,032,166.96 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 64,541,323.52 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,232,660,683.00 | 1,279,777,445.45 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,151,147,800.00 | 1,188,381,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,151,147,800.00 | 1,188,381,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 23,006,745.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,396,745.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 210,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 81,512,883.00 | 68,389,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 67,894,500.00 | 68,389,200.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,618,383.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,332,748,959.92 | 1,398,538,518.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,332,748,959.92 | 1,398,538,518.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,288,798,732.49 | 1,331,074,044.04 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,199,929.11 | 992,822,789.00 |
| 210101 | Үндсэн цалин | 731,048,762.00 | 569,690,099.00 |
| 210102 | Нэмэгдэл | 209,643,479.11 | 344,327,932.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,087,830.00 | 3,553,600.00 |
| 210104 | Урамшуулал | 29,419,858.00 | 75,251,158.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 130,541,727.60 | 129,465,770.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,668,100.00 | 89,885,543.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,621,343.60 | 9,622,090.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,875,000.00 | 8,007,599.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,868,184.00 | 2,014,816.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,509,100.00 | 19,935,720.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,226,503.86 | 63,406,766.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,712,524.11 | 23,033,666.97 |
| 210302 | Түлш, халаалт | 27,238,250.00 | 28,292,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,275,729.75 | 12,081,099.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,824,624.00 | 21,711,848.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 64,000.00 | 55,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,485,000.00 | 1,439,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | 123,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,221,324.00 | 638,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,093,800.00 | 2,428,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 896,500.00 | 3,167,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 13,861,148.20 |
| 2105 | Норматив зардал | 947,260.00 | 310,550.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 250,960.00 | 234,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 696,300.00 | 76,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,264,000.00 | 3,401,600.00 |
| 210602 | Тавилга | 1,725,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 539,000.00 | 3,401,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,168,000.00 | 10,434,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,160,000.00 | 10,434,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,626,687.92 | 109,520,019.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 650,800.00 | 1.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,912,538.50 | 6,642,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,063,349.42 | 102,877,418.97 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,950,227.43 | 67,464,474.13 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 24,195,100.00 | 45,608,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,391,100.00 | 44,448,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,741,000.00 | 1,160,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 11,366,246.14 | 13,107,533.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,366,246.14 | 13,107,533.53 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,388,881.29 | 8,748,640.60 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,388,881.29 | 8,748,640.60 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (34,145,931.40) | (100,434,505.76) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,598,135.00 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,598,135.00 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (6,598,135.00) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (40,744,066.40) | (100,434,505.76) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,951,445,903.10 | 4,515,928,762.16 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,951,445,903.10 | 4,515,928,762.16 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (40,744,066.40) | (40,744,066.40) |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,910,701,836.70 | 4,475,184,695.76 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,910,701,836.66 | 4,475,184,695.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,910,701,836.70 | 4,475,184,695.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (100,434,504.76) | (100,434,504.76) |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,872,083,874.65 | 692,398,984.41 | 1,810,267,331.90 | 4,374,750,190.96 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,254,079,781.00 | 1,291,206,345.45 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,401,022.00 | 11,428,900.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,401,022.00 | 11,428,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,401,022.00 | 11,428,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,401,022.00 | 11,428,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,252,678,759.00 | 1,279,777,445.45 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,151,147,800.00 | 1,188,381,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,151,147,800.00 | 1,188,381,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 22,749,600.00 | 23,006,745.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,396,745.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,749,600.00 | 210,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 67,894,500.00 | 68,389,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 67,894,500.00 | 68,389,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 10,886,859.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 10,886,859.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,249,084,381.00 | 1,291,866,345.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,249,084,381.00 | 1,291,866,345.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,194,310,294.57 | 1,225,824,971.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,199,929.11 | 992,822,789.00 |
| 210101 | Үндсэн цалин | 579,666,808.00 | 569,690,099.00 |
| 210102 | Нэмэгдэл | 326,803,933.11 | 344,327,932.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,327,630.00 | 3,553,600.00 |
| 210104 | Урамшуулал | 61,401,558.00 | 75,251,158.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 130,541,727.60 | 129,465,770.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,642,500.00 | 89,885,543.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,646,943.60 | 9,622,090.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,875,000.00 | 8,007,599.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,868,184.00 | 2,014,816.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,509,100.00 | 19,935,720.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,528,253.86 | 62,614,766.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,712,524.11 | 23,033,666.97 |
| 210302 | Түлш, халаалт | 27,540,000.00 | 27,500,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,275,729.75 | 12,081,099.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,203,724.00 | 8,904,345.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 126,400.00 | 3,263,745.45 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,485,000.00 | 1,439,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,440,000.00 | 647,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,938,424.00 | 638,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,213,900.00 | 2,916,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,186,460.00 | 2,227,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 250,960.00 | 815,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 935,500.00 | 1,412,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 664,000.00 | 4,699,600.00 |
| 210602 | Тавилга | 125,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 539,000.00 | 4,699,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,214,200.00 | 11,484,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,206,200.00 | 11,484,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,772,000.00 | 13,605,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 650,800.00 | 10,282,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,121,200.00 | 3,323,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 54,774,086.43 | 66,041,374.13 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,018,959.00 | 45,608,300.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 10,886,859.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,391,100.00 | 44,448,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,741,000.00 | 1,160,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 8,859,600.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 8,859,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 11,366,246.14 | 2,824,833.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,366,246.14 | 2,824,833.53 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,388,881.29 | 8,748,640.60 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,388,881.29 | 8,748,640.60 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 4,995,400.00 | (660,000.00) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 6,425,400.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,425,400.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,425,400.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 6,425,400.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (6,425,400.00) | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (1,430,000.00) | (660,000.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 2,209,242.73 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,209,242.73 | 1,549,242.73 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1257916900.00 | 1245197225.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1257916900.00 | 1245197225.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1212968600.00 | 1201395125.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1000943900.00 | 992822789.00 |
| 210101 | Үндсэн цалин | 637478000.00 | 569690099.00 |
| 210102 | Нэмэгдэл | 283006900.00 | 344327932.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3256200.00 | 3553600.00 |
| 210104 | Урамшуулал | 77202800.00 | 75251158.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 130093200.00 | 129465770.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90055400.00 | 89885543.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10009400.00 | 9622090.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8007600.00 | 8007599.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2001900.00 | 2014816.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20018900.00 | 19935720.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 65439600.00 | 62614766.47 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19445800.00 | 23033666.97 |
| 210302 | Түлш, халаалт | 27540000.00 | 27500000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18453800.00 | 12081099.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6157200.00 | 6157200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 804200.00 | 866600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,210,800.00 | 1,439,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 643,400.00 | 647,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 321,700.00 | 288,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,177,100.00 | 2,916,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,227,300.00 | 2,227,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 815,200.00 | 815,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,412,100.00 | 1,412,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,949,600.00 | 2,949,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,949,600.00 | 2,949,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,834,700.00 | 1,834,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,834,700.00 | 1,834,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,323,100.00 | 3,323,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,323,100.00 | 3,323,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,948,300.00 | 44,948,300.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 44,948,300.00 | 44,948,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 44,448,300.00 | 44,448,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,257,916,900.00 | 1,245,197,225.87 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,188,381,500.00 | 1,179,632,859.40 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,188,381,500.00 | 1,179,632,859.40 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 68,389,200.00 | 65,564,366.47 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 68,389,200.00 | 65,564,366.47 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,146,200.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,146,200.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 2,209,242.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,549,242.73 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 86.00 | 86.00 |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 56.00 | 56.00 |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 24.00 | 24.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын арван долоо дугаар сургууль нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Бүрэн дунд боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,298,104.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,981.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,086.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,011.9 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,209.2 | 1,549.2 | (660.0) |
| Авлага | - | 8,859.6 | 8,859.6 |
| Бараа материал | 96,135.1 | 87,512.9 | (8,622.2) |
| Үндсэн хөрөнгө | 4,376,840.3 | 4,276,828.4 | (100,011.9) |
| Нийт хөрөнгө | 4,475,184.6 | 4,374,750.1 | (100,434.5) |
| Засгийн газрын хувь оролцоо | 4,475,184.6 | 4,374,750.1 | (100,434.5) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,475,184.6 | 4,374,750.1 | (100,434.5) |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,549.2 мянган төгрөг болж 660.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ.

Авлагын эцсийн үлдэгдэл 8,859.6 мянган төгрөг нь 2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн зарцуулагдаагүй зардлын үлдэгдэл юм.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,512.9 мянган төгрөг болж 8,622.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал болох хөрс бутлагч сийрүүлэгч, түймрийн үүргийн шүршигч авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,276,828.4 мянган төгрөг болж 100,011.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны 2,865.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан хэдий ч элэгдлийн зардал 102,877.4 мянган төгрөг тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,255,944.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,196,518.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,972.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвөөс 1,257,916.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1,257,916.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,245,197.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 10,282.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,245,197,2 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 26,512.7 мянган төгрөг орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг хугацаандаа оруулж, мэдээлсэн байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 14 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тогтоосон 645.2 мянган төгрөгийн дүнтэй 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17 дугаар сургуулийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансыг үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 168,688.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 165,875.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,813.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Орлого үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг 77,796.5 мянган төгрөгөөр дутуу, төвлөрүүлэх шилжүүлгийг 10,282.7 мянган төгрөгөөр дутуу, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүү байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 77,796.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:*

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2,582.1 мянган төгрөгийн бичиг хэргийн болон цэвэрлэгээний материал худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", Сангийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байх.

***2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал***

2.1. *Илрүүлэлт:*

Тайлант онд 7, 10 дугаар ангийн сурагчдад зориулсан бодлого дасгалын номны хэрэгцээ шаардлагыг тооцоололгүй 42 ширхэг ном худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймгийн Баян-Өндөр сумын арван долоо дугаар сургууль | 3 | 168,688.8 | 1 | 165,875.7 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 2,813.1 |
| **Дүн** | | **3** | 168,688.8 | **1** | 165,875.7 | **0** | **0** | **0** | **0** | **2** | **2,813.1** |

Аудитын код: ОРА-2022/61/НА-СТА-ТШЗ